

2026.01.22 нд Сүхбаатар дүүргийн замын цагдаагийн хэлтэсээс “Тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрлэн дохио тавьж хэрэглэх журам” жолоочийн үүрэг, шинээр гарсан дүрэм журмын талаар нийт ажилчдад мэдээлэл хүргэсэн. Сургалтанд нийт 27 эмч, резидент хамрагдсан.



2026.03.13 нд Авлигатай тэмцэх газрын урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан комиссар А.Тунамал-Эрдэнэ “Авлигалаас урьдчилан сэргийлэх”, сэдвээр АӨСҮТ-ийн ажилчдад мэдээлэл хүргэсэн сургалтанд нийт 66 ажилтан албан хаагч хамрагдсан.



2026.04.02 нд сургагч багш Э.Жагар “Багийн ажиллагаа ба хувь хүний харилцаа хандлага” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Сургалтанд 23 эмч, ажилтан хамрагдсан.

2026.05.17-06.05 хугацаанд Герман улсын ахлах зэргийн арьсны эмч Susen Rode ажлын байрны сургалт зохион байгуулж 14 хоногын хугацааатай мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан.



5 сард Хэнтий аймгийн нэгдсэн эмнэлэг, аймгийн эрүүл мэндийн газартай хамтарч арьс харшлын эмчийн үзлэг хийж ажилчдад АӨСҮТ-ийн харшил судлалын лабораториос ургамлын 14 төрлийн сорил өгч харшлын их эмч С.Байгалмаа үзлэг хийсэн. Хэнтийн аймгийн арьс харшлын эмчид ганцаарчилсан сургалт явуулж харшлын кабинеттэй болох суурийг тавьж заавар зөвлөгөө өгсөн.



